



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 577

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 2,525,949,688.00 /хоёр тэрбум таван зуун хорин таван сая есөн зуун дөчин есөн мянга зургаан зуун наян найман/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө (барилга байгууламж, их засвар сайжруулалт)-ийг Баянхонгор аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн
577... дугаар тогтоолын хавсралт



**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Баянхонгор аймгийн
өмчид бүртгэж авах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн/төгрөг/	Улсын комиссын актын дугаар
1	Хөгжлийн бэршээлтэй иргэдийн хөгжлийн төв, Баянхонгор аймаг Баянхонгор сум	34.4м*17.9м хэмжээтэй зоорьтой 2 давхар барилга	1,016,018,437.00	2020.01.10 №2019/36
2	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Баянхонгор аймаг, Баацагаан сум	20.4м*17.6м хэмжээтэй 2 давхар	728,023,841.00	2019.12.15 №2019/35
3	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, их засвар, Баянхонгор аймаг, Өлзийт сум	20.4м*17.6м хэмжээтэй 2 давхар	781,907,410.00	2019.12.15 №2019/36
	Нийт дүн		2,525,949,688.003 /хоёр тэрбум таван зуун хорин таван сая есөн зуун дөчин есөн мянга зургаан зуун наян найман/	